

**“ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооноос тус тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригор ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Т.Доржханд, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд Байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгийн зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гадаад валютын захын үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалттай банкны эрх зүйн орчныг бүрдүүлэх, орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан Монголбанкнаас Засгийн газарт шилжүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй саналууд гаргасныг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Ц.ЦЭРЭНПУНЦАГ



**“ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн саналууд:

1.Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“9/Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Халамжаас хөдөлмөрт” зорилтын хүрээнд ажлын байрыг хадгалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрэлтэд нийцсэн ур чадвартай ажиллах хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, мөнгөний болон төсвийн бодлогоор дэмжих;”

**Санал гаргасан: Улсын Их хурлын гишүүн С.Чинзориг,
Х.Ганхуяг, Т.Доржханд, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл
/цаашид “Ажлын хэсэг” гэх/**

2.Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“10/валютын захын үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчдыг таньж мэдэх хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, түүнчлэн санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах;”

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“11/урт хугацааны тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын хөрөнгө оруулалттай төрөлжсөн банкны эрх зүйн орчныг бүрдүүлэх.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

4.Тогтоолын төслийн 2 дугаар заалтын 8 дахь дэд заалтын “2023 онд” гэснийг “2023 оны 2 дугаар улиралд” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их хурлын гишүүн Т.Доржханд

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО